



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2026/001/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Улиастай сум
2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: bat-undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Оюунсүвд
Утас: 99076038
Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn
Аудитор: Т.Баасанжаргал
Утас: 92012266
Цахим хаяг: baasanjargalt@audit.gov.mn
Аудитор: Л.Гансүлд
Утас: 88161818
Цахим хаяг: gansuldl@audit.gov.mn

АГУУЛГА

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3-4
2. АУДИТ ХИЙСЭН ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	5-7
2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	
2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	
2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	
2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	
3. АУДИТЫН ТАЙЛАН	
3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	7
3.1.1 Аудит хийсэн үндэслэл	7
3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ.....	7
3.1.3 Аудитын арга зүй.....	8
3.1.4 Материаллаг байдлын түвшин.....	8
3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ	
3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж.....	8
3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн.....	8
3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	9
3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан.....	9
3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан.....	9
3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	9
3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан.....	9
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	9
4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	10
4.3 АВЛАГА	10
4.4 УРЬДЧИЛГАА	11
4.5 БАРАА МАТЕРИАЛ	11
4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	12
4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	12
4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13
4.9 ӨР ТӨЛБӨР	14
Богино хугацаат Өр Төлбөр.....	14
Урт хугацаат Өр Төлбөр.....	14
4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	15
4.11 ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН БОЛОН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит.....	17
Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудит	17
Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит.....	17
4.12 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА	18
4.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	18
4.14 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	18
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	19
5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	19
5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

Хүснэгт-1	Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч
Хүснэгт-2	Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт-3	Авлагын үлдэгдэл
Хүснэгт-4	Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр
Хүснэгт-5	Бараа материал данс байгууллагын төрлөөр
Хүснэгт-6	Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт-7	Нийт өр төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт-8	Засгийн газрын хувь оролцоо
Хүснэгт-9	ТЕЗ-ийн харьяа ОНӨААН-үүдийн ашиг, алдагдал
Хүснэгт-10	Дүгнэлтийн хэлбэр
Хүснэгт-11	Өөрчлөлттэй дүгнэлт өгсөн байгууллагууд
Хүснэгт-12	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлээгүй, хөрөнгө оруулалтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан, харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд алдагдалтай ажиллаж байгаад дүн шинжилгээ хийж, санхүүгийн үр ашгийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, нийт 1,552.3 сая төгрөгийн зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Завхан аймгийн Засаг даргын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 4 бүлгийн хүрээнд 170 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 50 дугаар тогтоолоор 93.4 хувийн биелэлттэй буюу “**Үр дүнтэй**” гэж дүгнэжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 11,734.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 14 байгууллага хязгаарлалттай, 3 байгууллага сөрөг дүгнэлт авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭГ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		26,596,545.8	29,885,813.59
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	17,585,611.82	18,995,576.03
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	6,251,659.99	7,477,008.14
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	3,003.87	3,591.92
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	2,756,270.13	3,409,637.5
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		57,603,313.08	84,235,062.49
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	57,603,313.08	75,578,330.69
8	1.2.2.01 Газар		0.0	1,134.00
9	1.2.2.02 Биет хөрөнгө		53,399,135.75	71,225,833.05
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	4,204,177.34	4,351,363.64
11	1. НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		84,199,858.88	105,464,144.28
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,081,760.02	3,600,680.01
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		777,314.4	2,296,234.4
14	2.1.1.03 Өглөг		623,134.47	2,140,959.75
15	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	154,179.93	155,274.65
16	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,304,445.61	1,304,445.61
17	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	1,304,445.61	1,304,445.61
18	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		82,118,098.86	101,863,464.27
19	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		82,118,098.86	101,863,464.27
20	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		17,805,346.56	17,458,268.17
21	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		6,594,152.07	8,390,317.42
22	2.2.1.06 Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		202,588.04	202,588.04
23	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		228,205.06	228,205.06
24	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		51,074,260.02	68,430,947.16
25	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		6,213,547.13	7,153,138.43
26	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		84,199,858.88	105,464,144.28

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		108,574,324.91	117,615,984.76
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		27,412,196.45	31,847,916.35
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		22,264,016.16	24,776,277.5
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		22,035,694.44	23,539,301.52
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,208,652.6	-1,512,749.08
6	1.1.1.03.1.03 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		984.23	0
7	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар		1,435,990.09	2,749,725.06
8	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		2,363,018.9	2,726,088.77
9	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		2,785,161.38	4,345,550.08
10	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	78,289,684.47	85,768,068.4
11	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	7,512,413.99
12	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,872,443.98	0.0
13	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	67,576,575.7	76,473,348.04

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

14	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		67,576,575.7	74,148,605.79
15	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		65,003,336	72,001,085.4
16	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		22,847,307.19	27,344,625.21
17	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,880,224.55	3,570,638.56
18	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		15,586,414.97	18,020,056.6
19	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		2,072,304.98	2,040,980.38
20	1.1.2.01.1.05 Нормативт зардал		194,338.6	279,718.45
21	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		771,872.21	922,318.35
22	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		526,960.02	495,655.34
23	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,442,573	5,876,526.73
24	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		14,681,340.48	13,450,565.79
25	1.1.2.01.3 ТАТААС		0	30,000
26	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,573,239.69	2,117,520.39
27	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	2,324,742.25
28	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		40,997,749.21	41,142,636.72
29	1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	16,749.48
30	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		24,659,267.67	22,407,631.15
31	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		-24,659,267.67	-22,390,881.67
32	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		16,338,481.54	18,751,755.04

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,300,683.03	65,300,683.03
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	478,934.29	478,934.29
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,779,617.33	65,779,617.33
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	16,335,882.09	16,335,882.09
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,115,499.41	82,115,499.41
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	82,115,499.41	82,115,499.41
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,480,039.18	-1,480,039.18
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,635,460.23	80,635,460.23
9	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	142,575.24	142,575.24
10	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-646.11	-646.11
11	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	766,214.06	766,214.06
12	1.7 Тайлант үеийн үр дүн	20,319,860.85	20,319,860.85
13	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	101,863,464.27	101,863,464.27

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	95,182,937.67	100,141,977.96
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	27,412,196.45	31,847,916.35
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	22,264,016.16	24,776,277.5
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,208,652.6	-1,512,749.08
5	1.1.1.1.03.1.03 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	984.23	0.0
6	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	1,435,990.09	2,749,725.06
7	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	2,363,018.9	2,726,088.77
8	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	2,785,161.38	4,345,550.08
9	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	526,931.75	1,406,241.45
10	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	1,132,401.9	1,535,485.41
11	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,125,827.73	1,375,885.08
12	1.1.1.1.03.8.04 Бусад татвар	0.0	27,938.14
13	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,863,103.36	68,294,061.6
14	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	13,185,925.46	12,569,245.21
15	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	7,513,786.79
16	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	51,677,177.9	48,211,029.6
17	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,907,637.86	0.0
18	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,098,271.15	68,755,801.61
19	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	64,098,271.15	68,755,801.61
20	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,548,288.84	67,789,321.33
21	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,405,871.35	28,106,624.59
22	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,232,383.56	3,523,842.61
23	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,234,825.92	18,738,605.67
24	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	2,239,521.44	1,915,678.88
25	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	189,369.5	258,875.91
26	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	764,841.39	865,207.08
27	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	505,754.89	483,110.54
28	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,020,658.08	5,871,379.14
29	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	9,955,062.7	8,025,996.91
30	1.1.1.2.01.3 ТАТААС	0	30,000
31	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,549,982.31	936,480.28
32	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	31,084,666.52	31,386,176.35
33	1.1.2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	725	6,253.24
34	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	27,021,414.19	27,919,940.07
35	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,021,414.19	27,919,940.07
36	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	27,021,414.19	27,919,940.07
37	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-27,020,689.19	-27,913,686.83
38	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,246,346.1	1,941,825.67
39	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	94,611	120,699.64
40	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,340,957.1	-2,062,525.31
41	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,723,020.22	1,409,964.21
42	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,862,591.6	17,585,611.82
43	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,585,611.82	18,995,576.03

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Завхан аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС болон бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар дүгнэлт гаргахад аудитын зорилт чиглэсэн.

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгууд Аудитын Олон Улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төрийн сан, төсөл хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3 Аудитын арга зүй

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим хэрэгжүүлж гүйцэтгэлээ.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг авч үзсэн.

3.1.4 Материаллаг байдлын түвшин

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд 2025 оны нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 105,464.1 сая төгрөгөөс 1.5 хувь буюу 1,582.0 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь заалтын дагуу Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 08/352 тоот албан бичгээр Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Үүнд:

- *Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөв захирагч хоорондын ажил гүйлгээний давхардсан 174,41.8 сая төгрөгийг санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд цэвэрлэх бичилт хийсэн байна.*
- *Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр тайлагнасан байна.*

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлжээ.

3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны төрийн сангийн удирдлагын “finperform” цахим системээр нэгтгэн гаргасан бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В: Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, 1-28 тодруулгууд
ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
ТЕЗ-ийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр, төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 21,264.0 сая төгрөгөөр буюу 25.2 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Эзлэх хувь
Б	1	2	3=2-1	
Эргэлтийн хөрөнгө	26,596.5	29,885.8	3,289.2	28.3%
Эргэлтийн бус хөрөнгө	57,603.3	75,578.3	17,975.0	71.7%
Нийт хөрөнгө	84,199.9	105,464.2	21,264.2	125.2%
Нийт өр төлбөр	2,081.8	3,600.7	1,518.9	3.4%
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	82,118.1	101,863.4	19,745.3	96.6%
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	84,199.9	105,464.1	21,264.2	125.2%

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо зэрэг данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Нийт хөрөнгө өмнөх оноос 21,264.2 сая төгрөгөөр өсөхөд төсвийн хөрөнгөөр 2,524.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 19,760.1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, үндсэн хөрөнгө өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 18,751.8 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй байна.

Төсөвт байгууллага 15,904.1 сая төгрөг, төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн 2,211.3 сая төгрөг, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 714.3 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр дүн 78.0 сая төгрөгийн алдагдалтай байна.

3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо өмнөх оноос 19,745.4 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 2,413.2 сая төгрөгөөр өссөн байна.

3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлого 100,142.0 сая төгрөг, зарлага 68,755.8 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 31,386.2 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй байна.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 18,995.6 сая төгрөг болж, өмнөх оноос 1.410.0 сая төгрөгөөр өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 18,783.3 сая төгрөг буюу 98.8 хувь нь төрийн сангийн харилцах дансанд, 106.4 сая төгрөг буюу 0.6 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Кассад байгаа бэлэн мөнгө	10.8	15.6	4.8	0.08%
Банканд байгаа бэлэн мөнгө	17,574.8	18,980.0	1,405.2	99.92%
Төрийн сангийн харилцах	17,517.5	18,783.3	1,265.7	98.9%
Арилжааны банк дахь харилцах	55.8	196.7	140.9	1%
Нэмэлт санхүүжилт харилцах	1.5	-	-1.5	-
Дүн	17,585.6	18,995.6	1,410.0	100%
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	17.3	17.8	0.5	1%
Төсөл/сан	9,364.3	8,411.5	(952.8)	44.0%
Төрийн сан	8146.3	10,357.6	2,211.3	54.0%
ОНӨААН	57.7	208.7	151.0	1%
Дүн	17,585.6	18,995.6	1,410.00	100%

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд тайлант онд хийгдэж дуусаагүй хөрөнгө оруулалтуудын үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээ хийгдээгүй, санхүүжилтийн эрх нээгдээгүйгээс зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгоогүй, зарим сумдад нөхөн сэргээлтийн данс шинээр нээгдэж орлого төвлөрүүлсэн, Нөмрөг, Завханмандал, Сонгино, Яруу, Ургамал сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлага барагдаж үлдэгдэл өссөн болон Их-уул, Отгон, Ургамал, Асгат, Завханмандал сумдын татварын орлого давж биелсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 1 хувийг төсөвт байгууллага, 44 хувийг төсөл сан, 54 хувийг төрийн сан, 1 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх гэх үндэслэлээр төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг, уралдаан тэмцээний шагнал, урамшуулал, хоол хүнсний материал, бэлэг дурсгалд 1,285.0 сая төгрөг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн, их засварын зардлаас 50.0 сая төгрөгийг зориулалт бус төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, мөн барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлээс 217.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар хувь хүний дансаар мөнгө дамжуулан зарцуулж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан, орон тооны бүтцэд батлагдаагүй ажилд хавсарсан нэмэгдэл олгосон, цалин

урамшуулал илүү тооцож олгосон, аливаа хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлэхдээ үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үздэггүй, ажил гүйцэтгэсэн тайлан, анхан шатны баримт хангалтгүй, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын урьдчилгаа санхүүжилт олгосон боловч гэрээний хугацаанд бүрэн хийгдээгүй, хуульд зааснаас бусад хэлбэрээр тэтгэмж, урамшуулал, дэмжлэг олгосон, багийн өдөрлөг, урлаг, спортын тэмцээн зохион байгуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн зэрэг зөрчил илэрсэн байна.

4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат хөрөнгө оруулалттай холбоотой бүртгэл байхгүй байна.

4.3 АВЛАГА

Авлага дансны эцсийн үлдэгдэл 7,477.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,225.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь 22 сум хоршоо хөгжүүлэх сангаас 1,941.8 сая төгрөгийн зээл олгож авлага үүсгэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Нийт авлагын үлдэгдлийн 6.9 хувийг төсөвт байгууллага, 87.4 хувийг төсөл сан, 2.7 хувийг төрийн сан, 3 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага тус тус эзэлж байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой авлага	23.4	15.7	-7.65	21.0%
Төлбөртэй үйлчилгээний авлага	19.5	389.5	-30.0	5.2%
Татаас, санхүүжилтийн авлага	-	22.2	22.2	0.3%
Данс авлага /ТӨҮГ/	92.3	168.9	76.5	2.6%
Татвар НДШ авлага /ТӨҮГ/	0.7	0.6	-0.0	0.0%
Байгууллагаас авах авлага	856.1	1,418.8	562.6	18.9%
Хувь хүмүүсээс авах авлага	4,859.70	5,461.3	601.5	73.0%
Дүн	6,251.70	7,477.0	1,225.3	119.6%
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	269.8	518.2	248.4	6.9%
Төсөл/сан	5,660.8	6,535.9	875.1	87.4%
Төрийн сан	199.2	199.3	0.1	2.7%
ОНӨААН	121.9	223.6	101.7	3%
Дүн	6,251.70	7,477.0	1,225.3	119.6%

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь төсөвт байгууллагуудын авлага 248.4 сая төгрөгөөр, төсөл сангийн авлага 875.1 сая төгрөгөөр, төрийн сангийн авлага 0.1 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн авлага 101.7 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын хүрээнд тайлант онд үүссэн авлагыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, авлагыг дутуу болон зөрүүтэй тайлагнасан, хэмнэгдсэн зардлыг НДШ-д шилжүүлж авлага үүсгэсэн, он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хугацаа хэтэрсэн авлагыг шүүхийн байгууллагад шилжүүлээгүй, шүүхийн шийдвэрийн хугацаа дууссан байхад шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэн барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

4.4 УРЬДЧИЛГАА

Урьдчилж гаргасан зардал дансны үлдэгдэл 3.6 сая төгрөг болж, 0.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
----------	----------------	-----------------	------------------------	-----------------

Урьдчилж гарсан зардал	3.0	3.6	0.6	100%
Дүн	3.0	3.6	0.6	100%
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	-	-	-	
ОНӨААН	3.0	3.6	0.6	100%
Дүн	3.0	3.6	0.6	100%

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд бүртгэлтэй 3.6 сая төгрөгийн үлдэгдлээс 2.0 сая төгрөг нь Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны 2022 онд гэрээгээр хөрсний гүний бохирдол хэмжих ажил гүйцэтгүүлэхээр, 1.6 сая төгрөг нь “Тосон очирт хайрхан” ОНӨААН-ийн цалингийн урьдчилгаатай холбоотой урьдчилж гарсан зардал байна.

4.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 3,409.6 сая төгрөг болж, өмнөх оноос 653.3 сая төгрөгөөр өссөн байна. Нийт бараа материалын үлдэгдлийн 84.3 хувийг төсөвт байгууллага, 15.7 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн бараа материал тус тус эзэлж байна.

Хүснэгт №5. Бараа материал данс байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)	Хувь
Түүхий эд материал	145.3	215.9	70.5	6%
Тусгай зориулалттай материал	142.0	164.5	22.5	5%
Эм боох материал	2.4	50.5	48.1	1%
Бэлэн бүтээгдэхүүн	0.9	0.9	-	0%
Хангамжийн материал	2,534.5	3,084.3	549.8	90%
Бичиг хэргийн материал	69.1	77.8	8.7	2%
Аж ахуйн материал	1,179.0	1,148.9	(30.1)	34%
Сэлбэг хэрэгсэл	58.0	55.9	(2.1)	2%
Түлш, шатах тослох материал	77.5	33.3	(44.2)	1%
Барилгын засварын материал	50.0	45.1	(4.9)	1%
Хүнсний материал	0.1	-	(0.1)	0%
Бусад хангамжийн материал	1,100.9	1,723.4	622.5	51%
Мал амьтад	76.4	109.5	33.0	3%
Дүн	2,756.3	3,409.6	653.3	124%
Байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	2,370.2	2,948.9	578.7	84.3%
ОНӨААН	386.1	460.7	74.6	15.7%
Дүн	2,756.3	3,409.6	653.3	124%

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал 653.3 сая төгрөгөөр өссөн нь түүхий эд материал 70.5 сая төгрөгөөр, хангамжийн материал 549.8 сая төгрөгөөр, мал амьтад 33.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 3,531.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 333.8 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтаар 446.5 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, балансаас баланст 80.3 сая төгрөгийн материал шилжүүлэн авч нийт 4,391.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 3,430.0 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулан, 72.2 сая төгрөгийн бараа материалыг балансаас баланст шилжүүлж, 234.7 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын хүрээнд худалдан авсан бараа материалыг тодруулга тайлангаар дамжуулаагүй, шууд зардлаар тайлагнасан, бараа материалыг зөв ангилж бүртгээгүй, бараа материалыг нэр төрөл, тоо ширхгээр бүртгээгүй бөөн дүнгээр орлого авсан, хөрөнгө оруулалтаар ирсэн бараа материал болон ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс тэжээлийг данс

бүртгэлд тусгаагүй, бараа материалын жилийн эцсийн тооллого хийгээгүй, эргэлтийн хөрөнгийг карталж ашиглалтын бүртгэл хөтлөөгүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

4.5 НӨӨЦИЙН БАРАА

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нөөцийн бараа данстай холбоотой бүртгэл байхгүй байна.

4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бусад эргэлтийн хөрөнгө данстай холбоотой бүртгэл байхгүй байна.

4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт данстай холбоотой бүртгэл байхгүй байна.

4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 75,578.3 сая төгрөг болж, өмнөх оноос 17,975.0 сая төгрөгөөр өссөн байна. Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 87 хувийг төсөвт байгууллага, 13 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	53,399.0	71,225.8	17,826.8	94%
Барилга, байгууламж, орон сууц	28,997.6	36,184.7	7,187.1	48%
Авто-тээврийн хэрэгсэл	8,036.4	10,119.8	2,083.4	13%
Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,160.1	10,895.2	1,735.1	14%
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,091.7	1,439.1	347.4	2%
Зам гүүрний байгууламж	22.8	5,302.1	5,279.3	7%
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	3.7	3.7	0.0	0%
Бусад үндсэн хөрөнгө	6,056.4	7,250.9	1,194.5	10%
Ном	30.3	30.3	0.0	0%
Биет бус хөрөнгө	4,204.3	4,352.5	148.2	6%
Программ хангамж	69.6	53.9	(15.7)	0%
Газар		1.1	1.1	0%
Бусад биет бус хөрөнгө	4,134.7	4,297.5	162.8	6%
Дүн	57,603.3	75,578.3	17,975.0	131%
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	49,723.2	65,663.4	15,940.2	87%
ОНӨААН	7,880.1	9,914.9	2,034.8	13%
Дүн	57,603.3	75,578.3	17,975.0	131%

Эх сурвалж: Завхан аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт нь төсвийн хөрөнгөөр 2,524.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 19,760.1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, 1,801.1 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, 577.0 сая төгрөгийн хөрөнгө дахин үнэлж бүртгэсэн, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 197.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдсан, 1,895.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан, 975.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, аудитын шийдвэрээр 361.8 сая төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлсэн, мөн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ч цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдэд үнэ тогтоож, дахин үнэлгээний хорогдол 736.0 сая төгрөгөөр хасагдсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгө болон сумдад эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй 476.8 сая төгрөгийн болон аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийг журам зөрчсөн төсөл арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ

гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүй 3.891.2 сая төгрөгийн зөрчил давтагдан гарч байгаад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг зөв тодорхойлоогүй, элэгдэл дутуу тооцоолсон, жилийн эцсийн тооллого хийгээгүй, тооцоо бодож баримтжуулаагүй, хөрөнгийн ашиглалтын карт хөтлөөгүй, үлдэх өртөггүй хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

